



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,  
Сүхбаатарын талбай-6,  
Утас: 26-30-83, Факс: 26-12-73  
E-mail: Office@president.mn

2017. 10.05 № 11/451  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Ц.ЦОЛМОН ТАНАА


Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
захирамж хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн  
"Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр томилуулах тухай" 15 дугаар  
захирамжийг үүгээр хүргүүлж байна.

Зохих журмын дагуу шийдвэрлүүлж өгөхийг хүсье.

Хавсралт 08 хуудас.

ДАРГА



З.ЭНХБОЛД

0000002155



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАХИРАМЖ

2014 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 15

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр томилуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Раднаагийн Бурмааг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА

ХУУЛБАР ҮНЭН:

Дэд даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч



Г.Байгалмаа

0000000093

## ТАНИЛЦУУЛГА

/Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч/

- 1.Овог нэр:** Раднаагийн БУРМАА
- 2.Хэзээ, хаана төрсөн:** 1958 онд Улаанбаатар хотод төрсөн.
- 3.Нас, хүйс:** 59 настай, эмэгтэй.
- 4.Үндэс, угсаа:** Буриад.
- 5.Ам бүлийн байдал:** Хоёр.



**6.Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг цол:**

- 1975 онд нийслэлийн 52 дугаар дунд сургууль
- 1982 онд БНБАУ-ын Электрон Техникийн Их сургууль
- 1987 онд МУИС-ийн англи хэлний дээд курс
- 1992 онд Удирдлагын хөгжлийн институт.

**7.Ажилласан байдал:**

- 1982-1988 ШУА-ийн Физикийн хүрээлэнд эрдэм шижилгээний ажилтан
- 1988-1992 онд МОНЭЛ фирмд инженер, зохион бүтээгч
- 1992-1996 онд Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний тэргүүн
- 1996-1997 онд Хүүхдийн төлөө төвийн дарга
- 1997-2012 онд Сонгогчдын Боловсрол Төвийн захирал
- 2000-2006 онд Сонгуулийн Ерөнхий Хорооны гишүүн
- 2005-2011 онд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн
- 2009-2012 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх
- 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн
- 2012-2014 онд Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга
- 2014-2016 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, Хөдөө аж ахуйн сайд
- 2009-2012, 2017 оноос АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн.

## РАДНАА ОВОГТОЙ БУРМААГИЙН АЖИЛ БАЙДЛЫН

### ТОДОРХОЙЛОЛТ

Раднаагийн Бурмаа нь Улаанбаатар хотын харьяат, 1965-1975 онд Улаанбаатар хотын 52-р дунд сургууль, 1975-1982 онд Болгар улсын Техникийн Их сургууль, 1991-1992 онд Удирдлагын Хөгжлийн Институтийг тус тус төгссөн. Электроникийн инженер мэргэжилтэй. Удирдлагын ухааны магистр цолтой, Болгар, Орос, Англи хэлтэй. Төрийн дээд шагнал болох Алтангадас одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан.

1982-1988 онуудад ШУА-ийн Физикийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1988-1992 онуудад "Монэл" фирмд зохион бүтээгч-инженер, 1992, 1997 оноос 2012 он хүртэл Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний тэргүүн, Сонгогчдын Боловсрол Төвийн захирал, 2000-2006 онд Сонгуулийн Ерөнхий Хорооны гишүүн, 2009-2012 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, 2005-2011 онд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн Үндэсний Зөвлөлийн гишүүн, 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2012-2014 онд Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга, 2014-2016 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байсан болно. Одоо Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Түүнчлэн, Ардчилалд сонгуульд туслах олон улсын хүрээлэнгийн удирдах зөвлөлийн гишүүнээр 2013-2016 онд, Чөлөөт шударга сонгуулийн Азийн сүлжээ байгууллагын удирдах зөвлөлийн гишүүнээр 2016 оноос сонгогдон ажиллаж байна.

Р.Бурмаа нь ардчилсан нийгмийг төлөвшүүлэх, ардчиллын зарчмуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүднээс 1992 оноос "Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн" төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулж эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалал, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан ба 1997 оноос иргэний боловсролыг дээшлүүлэх, ардчилсан нийгэм дэх ухамсартай сонголтыг төлөвшүүлэх, төрийн байгууллагын бодлого, шийдвэрт олон нийтийн оролцоог хангах зорилгоор иргэдийг хамарсан үйл ажиллагаа явуулах зорилго бүхий Сонгогчдын Боловсрол Төвийг байгуулан ажиллажээ. Сонгогчдын Боловсрол Төв нь ухаалаг сонголт хийхэд нь иргэдэд мэдээллээр туслах, иргэний боловсролыг нь дээшлүүлэх, төрийн түшээд сонгогчдын харилцааг сайжруулах, сонгуулийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Тухайлбал, УИХ-ын Тамгын газартай хамтран сонгуулийн хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, Сонгуулийн ерөнхий хорооны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудал дээр хамтарч ажиллажээ.

1996, 1997, 2000, 2001, 2004, 2005, 2008, 2009 оны сонгуулиудад сонгогчдын эрх үүргийг ойлгуулах, улс төрийн нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, бусад мэдээллийг олон нийтэд хүргэх, сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагаанд оролцогч талуудыг чадавхижуулах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. 2005 онд УИХ-ын сонгуулийн тухай хуулийг шинэчлэхэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, тодорхой саналуудыг хуульд тусгуулж ажилласан байна.

1997 оноос хууль тогтоох үйл явцыг иргэдэд нээлттэй болгох, ялангуяа залуучууд, хүүхдүүдэд ойлгуулах үүднээс “Мини ИТХ”, “Мини парламент”, “Мини Засгийн газар”-ыг орон нутаг, үндэсний хэмжээнд Улсын Их Хурлын Тамгын газар, олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Олон улсын харилцаа, НҮБ-ын үйл ажиллагаа, Олон улсын конвенци, баримт бичгүүдтэй хүүхэд залуучуудыг танилцуулах зорилгоор “Нэг ертөнц” НҮБ-ын цуврал бага хурлуудыг дэлхийд анх удаа Монгол улсад НҮБ, Засгийн газартай хамтран зохион байгуулж байжээ.

Парламентын болон хууль тогтоох үйл ажиллагааг илүү нээлттэй болгох, сонгогч сонгогдогчдын харилцааг сайжруулах, иргэдийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Улсын Их Хурлын Тамгын газар, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн, Үндэсний түүхийн музей 1997 оноос эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, чуулганы хуралдааныг телевизээр үзүүлэх, УИХ-ын гишүүд, иргэдтэй уулзалт зохион байгуулах, УИХ-ын чуулганы тэмдэглэл болон хууль тогтоох үйл явцтай холбоотой мэдээлэл бүхий номын сангаар үйлчлэх, сургалт семинари, уулзалтуудыг тогтмол зохион явуулж байлаа.

Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг нээлттэй болгох ажлын хүрээнд Газрын тухай хууль, Төсвийн байгууллага удирдлага санхүүжилтийн тухай хууль, УИХ-ын сонгуулийн тухай хуулиар олон нийтийн хэлэлцүүлэг, иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулж байсны зэрэгцээ тухайн үед хүний эрхийг хангах, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, сонгуулийн үйл явц, авлигын эсрэг зэрэг хууль тогтоомжийн ажлын хэсгүүдэд орж ажиллаж байсан.

Р.Бурмаа нь Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсоны дараа иргэд, сонгогчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Улсын Их Хуралд байгуулагдсан Өргөдлийн байнгын хорооны анхны даргаар нь ажиллан өргөдөл, гомдлоор дамжуулан төрийн байгууллагын хариуцлагатай болгох алхамд чухал хувь нэмрээ оруулж ажилласан байна.

Түүнчлэн, 2014 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байхдаа Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогыг боловсруулан батлуулж, энэхүү бодлогын хүрээнд салбарын олон хууль тогтоомж тухайлбал, Органик хүнсний тухай хууль, Тариалангийн тухай хууль зэргийг батлуулж хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд идэвхитэй ажиллажээ.